



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, 272,460,247.83 (хоёр зуун далан хоёр сая дөрвөн зуун жаран мянга хоёр зуун дөчин долоон төгрөг наян гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 233,779,638.59 (хоёр зуун гучин гурван сая долоон зуун далан есөн мянга зургаан зуун гучин найман төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Х.Ганчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т уурэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133001399
13-r huraldaah.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭИ, НЭЭЛТТЭИ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	ТӨБЗГ-ын 2024 оны 592 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
1	УАЗ пургон маркийн, 19-09 БРА улсын дугаар, 374100E0440690 арлын дугаар	2014.09.30	ш	1	47,927,668.92	47,927,668.92	37,755,406.01	10,172,262.91	10,200,000.00	5,100,000.00
2	Авто кран маркийн, тусгай зориулалтын, 04-87 ДГС улсын дугаар, LGHXBD1H096608601 арлын дугаар	2010.06.30	ш	1	73,831,079.54	73,831,079.54	73,831,079.54	-	30,000,000.00	15,000,000.00
3	Пик-Ап Pick-up маркийн, 47-99 БРА улсын дугаар, LGWDB3170CC658226 арлын дугаар, суудлын	2012.08.31	ш	1	39,889,945.79	39,889,945.79	39,889,945.79	-	2,500,000.00	1,250,000.00
4	Авто кран маркийн, 97-17 ХЭА улсын дугаар, LGHXCD1M2BH068687 арлын дугаар, тусгай зориулалтын	2011.12.31	ш	1	110,811,553.58	110,811,553.58	82,303,207.25	28,508,346.33	30,000,000.00	15,000,000.00
Нийт дүн						272,460,247.83 (хоёр зуун далан хоёр сая дөрвөн зуун жаран мянга хоёр зуун дөчин долоон төгрөг наян гурван мөнгө)	233,779,638.59 (хоёр зуун гучин гурван сая долоон зуун далан есөн мянга зургаан зуун гучин найман төгрөг тавин есөн мөнгө)	38,680,609.24 (гучин найман сая зургаан зуун наян мянга зургаан зуун есөн төгрөг хорин дөрвөн мөнгө)	72,700,000.00 (далан хоёр сая долоон зуун мянга)	36,350,000.00 (гучин зургаан сая гурван зуун тавин мянга)